



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/238

Арвайхээр

Хуулийн байгууллагуудын нэгдсэн өдөрлөг, хяналт, шалгалтын арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.3.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага болон олон нийтийн төлөөллийг оролцуулан байгууллагын дотоод хяналтын дүрэм журмын хэрэгжилт, хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдын сахилга, ёс зүйн болон гэмт хэргийн шинжтэй байж болох үйлдэлд иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэж буй байдал, иргэдийн сэтгэл ханамжийг судлах, сургалт мэдээллийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, таслан зогсоох, хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагаан дахь хүний эрхийн хандлагыг нэмэгдүүлэх, уялдаа холбоог хангах нэгдсэн арга хэмжээний удирдамж, чиглэл, зардлын тооцоог 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, судалгааны мөрөөр гарсан зөрчлийг арилгуулах, хариуцлага тооцох арга хэмжээ авч тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

4. Судалгаа, сургалтын арга хэмжээнд шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



6222 11 0519

Аймгийн Засаг даргын 2022 оны
05 дугаар сарын 11-ны өдрийн
... дугаар захирамжийн
... дүгээр хавсралт

МОНИТОРИНГИЙН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: Б.Эрхэмбаатар (аймгийн Прокурорын газрын дарга, Хууль цаазын шадар зөвлөх) (зөвшилцсөнөөр)

А.Отгонцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Б.Мөнх-Эрдэнэ (аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа)

Ч.Хүрэлбаатар (аймгийн Засаг даргын дэргэдэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, хурандаа)

Т.Цэдэнсодном (аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)

Б.Батнэргүй (Залуусын элч төрийн бус байгууллагын тэргүүн, хүний эрхийн судлаач)

Нарийн бичгийн дарга: Б.Анхбилэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

Аймгийн Засаг даргын 2022 оны
05 дугаар сарын 25-ны өдрийн
1/238 дугаар захирамжийн
01 дугаар хавсралт

**“ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЛИЙГ НЭР ДОРООС”
НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

2022.05.13

Арвайхээр

Зорилго: Өвөрхангай аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хууль, хяналтын байгууллагуудаас авч хэрэгжүүлж байгаа ажлын үр дүн, хамтын ажиллагаа, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд шинэ санал санаачилга хэрэгжүүлэх, иргэдэд олон нийтэд нэгдсэн мэдээллийг олгох, эрх зүйн сургалт зохион байгуулах, аймгийн хэмжээнд гэмт хэргийн гаралт өсөх болсон шалтгаан нөхцөл, цаашид авах арга хэмжээ, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад анхаарах асуудлын талаар хэлэлцэн, шийдвэрлэх арга замыг тодорхойлох.

Ерөнхий зохион байгуулагч:

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс

Хамтран зохион байгуулагч:

- Аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилэн сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
- Аймгийн Шүүх
- Аймгийн Прокурорын газар
- Аймгийн Засаг даргын дэргэдэх хууль, хяналтын байгууллагууд
- Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөл
- Монголын Хуульчдын Холбооны Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөл
- Залуусын элч ТББ

Хугацаа: 2022 оны 05 дугаар сарын 25

Хаана: Арвайхээр хотын “Аюуш” баатрын талбайд

Үр дүн: Өвөрхангай аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, таслан зогсоох, хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагаан дахь хүний эрхийн хандлагыг нэмэгдүүлэх, уялдаа холбоог хангах уг ажлыг зохион байгуулахад аймгийн нутгийн захиргаа, хуулийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, гэмт хэргийн гаралтыг бууруулахад хамтран ажиллах талаар шийдвэр гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллах талаар оролцогч байгууллагуудад үүрэг чиглэл өгнө.

**ХУУЛЬ, ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЛИЙГ НЭР ДОРООС”
НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧИГЛЭЛ**

2022 оны 05 дугаар сарын 13

Арвайхээр

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Зохион байгуулагч
1.	Өдөрлөг, арга хэмжээний хөтөлбөр гаргаж, байгууллагуудад хүргүүлэх	05 дугаар сарын 15	А.Отгонцэцэг	Хууль, эрх зүйн хэлтэс
2.	Аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага болон олон нийтийн төлөөллийг оролцуулан мониторинг хийх	5 дугаар сарын 15 6 дугаар сарын 15 хооронд	Б.Бат-Нэргүй ТББ	Хууль, эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
3.	Сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Иргэний зөвлөл, эрх зүйн сургалт хариуцсан албан тушаалтнуудад Бүх нийтийн эрх зүйн боловсрол хөтөлбөрийн хүрээнд арга зүйн сургалт, сурталчилгааны чиглэл өгөх	5 дугаар сарын 26	Б.Анхбилэг Т.Цэдэнсодном	Хууль эрх зүйн хэлтэс, Хууль зүйн Үндэсний хүрээлэн
4.	Хуулийн байгууллагуудын удирдлагуудтай уулзалт хийж, хамтын ажиллагааны талаар санал солилцож, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх	5 дугаар сарын 27	А.Отгонцэцэг Т.Цэдэнсодном	Хууль, эрх зүйн хэлтэс